



НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 09 сарын 06 өдөр

Дугаар 2/29

Улаанбаатар хот

Л.Норовыг ажилд томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт, Засгийн газрын 2014 оны 332 дугаар тогтоолыг тус тус ҮНДЭСЛЭН тушаах нь:

1. Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн Дэмбэрэлсамбуугийн Эрдэнэбилэгийг ажилд орох хүртэл жирэмсний амралтын хугацаанд 2017 оны 09 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн Лхамсүрэнгийн Норовыг томилон ажиллуулсугай.

2. Л.Норовын сарын үндсэн цалинг төрийн захиргааны ангиллын ТЗ-5 дугаар зэрэглэлийн 5 дугаар шатлалаар 628.344 /зургаан зуун хорин найман мянга гурван зуун дөчин дөрвөн/ төгрөгөөр цалинжуулж, хууль тогтоомжид заасан бусад нэмэгдлийн хамт тооцож олгохыг нягтлан бодогч /Б.Батбаатар/-т зөвшөөрсүгэй.

3. Л.Норовд байгууллагын дотоод журам, ажил үүргийн хуваарийг танилцуулахыг Бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Г.Гантүшиг/-т даалгасугай.

ДАРГА



П.БАТХҮЛЭГ